

UCS 1706A:2022

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ




Барилгын хог хаягдлын менежмент

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Барилгын хог хаягдлын менежмент

*Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 25-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	5
2. Норматив эшлэл.....	5
3. Нэр томъёоны тодорхойлолт.....	5
4. Ерөнхий шаардлага.....	6
5. Барилгын хог хаягдлын эх үүсвэрүүд	8
6. Барилгын хог хаягдлыг ангилах, хадгалах үйл ажиллагаа.....	10
7. Барилгын хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаа.....	14
8. Барилгын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа.....	14
9. Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа	16
10. Барилгын хог хаягдлыг устгах, булшлах үйл ажиллагаа	17
11. Барилгын аюултай хог хаягдал	18
12. Барилгын хог хаягдлын менежмент	20
Ашигласан материалын жагсаалт	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Барилгын ажлын талбайн хог хаягдал цуглуулах зохион байгуулалтын зураг	7
Зураг 2. Суурийн шороо	8
Зураг 3. Барилга угсралтын хог хаягдал	8
Зураг 4. Сав баглааны хаягдал	9
Зураг 5. Өнгөлгөөний материалын хаягдал	9
Зураг 6. Хаалга, цонхны хаягдал	9
Зураг 7. Цаас, обой	12
Зураг 8. Хаалга, цонхны хүрээ	12
Зураг 9. Хаягдал төмөр	12
Зураг 10. Авто замын хуучин асфальт бетон	12
Зураг 11. Хаягдал мод, модон эдлэл	12
Зураг 12. Шил, шилэн эдлэл	12
Зураг 13. Хаягдал арматур	13
Зураг 14. Картон цаас	13
Зураг 15. Зэс, гууль	13
Зураг 16. Суурийн блок	13
Зураг 17. Бүх төрлийн ялуу	13
Зураг 18. Төмөр бетон дам нуруу	13
Зураг 19. Модон эдлэл	13
Зураг 20. Тоосго /ашиглаж болохыг ялгах/	13
Зураг 21. Хучилтын хавтан	13
Зураг 22. Хаягдал асбест хавтан	14
Зураг 23. Бохирдсон бетон, тоосго, керамикийн хаягдал	14

Зураг 24. Барилгын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж талбайг чөлөөлөх	14
Зураг 25. Барилгын хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагааны зураглал.....	15
Зураг 26. Барилгын хог тээвэрлэх автомашин	16
Зураг 27. Дахин боловсруулах үйлдвэрлэлийн зураглал	16
Зураг 28. Сандаг	17
Зураг 29. Резин хавтан	17
Зураг 30. Хуванцар хоолой	17
Зураг 31. Шил	17
Зураг 32. Хуванцар эдлэл	17
Зураг 33. Ариун цэврийн цаас	17
Зураг 34. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршил	18
Зураг 35. Асбест агуулсан барилгын материал	19
Зураг 36. Хог хаягдлын менежментийн зарчим.....	20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1м ² талбайд ногдох барилгын хог хаягдлын норматив	8
Хүснэгт 2. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт /Барилгын хог хаягдал бүлэг/	10
Хүснэгт 3. Барилгын аюултай хог хаягдлын жагсаалт.....	19
Хүснэгт 4. Барилгын хог хаягдлын менежментийн сургалтын жишиг төлөвлөгөө	21



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

┌ Хог хаягдлын менежментэд хамаарах ┐
хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Хог хаягдлын менежмент бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

- 1.1. UCS1703A:2022 “Аюултай хог хаягдлын менежмент” хотын стандарт
- 1.2. UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт
- 1.3. UCS 1706A:2022 “Барилгын хог хаягдлын менежмент” хотын стандарт
- 1.4. UCS1704A:2022 “Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны менежмент” хотын стандарт
- 1.5. UCS1705A:2022 “Хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж” хотын стандарт

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100325



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 25...
дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

UCS 1706A:2022 “БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандарт нь барилгын хог хаягдал цуглуулах, ангилах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, тээвэрлэх, устгахад дагаж мөрдөнө.

2. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- Хог хаягдлын тухай хууль;
- “Аюултай хог хаягдлын жагсаалт” Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 116 дугаар тогтоол;
- Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах журам (Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаал);
- Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дүгээр тушаал);
- БНБД 81-95-12 /2020/ Барилгын төсөв зохиох дүрэм;
- MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага;
- MNS4598:2011 Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага.

3. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Хог хаягдал - гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материал;

Барилгын хог хаягдал – гэж барилгын суурь бэлтгэх, барилга барих буюу угсралт, засварлах, буулгах болон авто зам барих, засварлах, явган хүний зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, инженерийн шугам сүлжээ тавих, засварлах, солих үед үүсэх болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэлээс гарах хог хаягдал;

Хог хаягдал цуглуулах - гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор эх үүсвэрээс төвлөрүүлэх;

Хог хаягдал хадгалах - гэж байгаль орчин, хүн амьтанд сөрөг нөлөөлөлгүйгээр хог хаягдлыг савлаж байршуулах;

Хог хаягдал ангилах - гэж хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах, устгах, булшлах зорилгоор төрөлжүүлэн ялгах;

Барилгын ажлын талбай – гэж барилгын ажил гүйцэтгэж байгаа газар;

Барилгын суурийн шороо – гэж барилгын суурийг бэлтгэж ухах үед гарсан шороо;

Овор хэмжээ ихтэй хог хаягдал – гэж 0.75 куб метрээс дээш эзлэхүүнтэй хог хаягдал;

Хог хаягдал цуглуулах цэг – гэж хүний амьдрах орчин, үйл ажиллагаанаас үүссэн ахуйн хог хаягдлыг цуглуулсан бөөгнүүлэх зориулалтаар тоноглож, төхөөрөмжлөгдсөн талбай, хашлага, зөвшөөрөгдсөн цэг;

Хог хаягдлын норматив – гэж нэгж үйлдвэрлэл, үйлчилгээ, иргэнээс үүсэх хог хаягдлын тогтоосон хэмжээ;

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах – гэж хог хаягдал бага үүсгэдэг, үр ашигтай, удаан хугацаанд ашиглах боломжтой бүтээгдэхүүн импортлох, хэрэглэх болон хог хаягдалгүй, эсхүл хамгийн бага хэмжээгээр үүсгэдэг технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа;

Хог хаягдлыг дахин ашиглах – гэж ашиглагдаж байсан зорилгоор нь хог хаягдлыг эргүүлэн хэрэглээнд оруулах үйл ажиллагаа;

Хог хаягдлыг дахин боловсруулах – гэж хог хаягдлаас шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа;

Хог хаягдлыг устгах – гэж хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх зорилгоор ландфилл-д булшлах, биологийн болон хими, физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалах үйл ажиллагаа;


Ландфилл – гэж хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр газарт булшилж хадгалах байгууламж;

Хог хаягдлын төвлөрсөн цэг – гэж хог хаягдал төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газар;

Хог хаягдлын үйлчилгээний хураамж – гэж хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, булшлахад шаардагдах зардлын хувь хэмжээг харгалзан тогтоосон татвар.

4. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 4.1. Барилга, хот байгуулалтын Сайдын 2020 оны 48 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын дагуу ангилах, хадгалах, цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг явуулна.
- 4.2. Барилгын хог хаягдал үүсгэгч нь “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-тэй ажиллаж, төлөвлөгөөний тайланг ажил дууссанаас хойш 1 сарын дотор аймаг, нийслэлийн барилгын салбарын төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.
- 4.3. Барилгын хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлыг ангилах, хадгалах, цуглуулах байршлыг талбайн зохион байгуулалтын зураг төсөлд тодорхой заасан байна.
- 4.4. Барилгын хог хаягдлыг үүсгэгч нь барилгын хог хаягдлыг эх үүсвэр дээр нь багасгах боломжийг бүрдүүлж ажиллана.
- 4.5. Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцана.
- 4.6. Хог хаягдал үүсгэгч нь орон нутгийн онцлог, нөхцөл байдалд тулгуурлан шинэ санаа, шинэ арга, олон улсын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх замаар хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- 4.7. Хог хаягдлын мэргэжлийн ажилтан ажиллуулах шаардлагатай.
- 4.8. Барилгын хог хаягдал үүсгэгч нь ажилтнууддаа хошг хаягдлын сургалт зохион байгуулж зохих дадлагажуулж зуршил бий болгоно.
- 4.9. Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх шаардлагатай (Хог хаягдлын тухай хууль, 10.2.16).



Зураг 1. Барилгын ажлын талбайн хог хаягдал цуглуулах зохион байгуулалтын зураг (Жишээ зураг)

- 4.10. Барилгын хог хаягдал тээвэрлэгч нь тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээ, тогтоосон чиглэлийн дагуу тээвэрлэлт хийсэн хуваарь, цаг хугацааны талаарх мэдээ тайланг сар бүрийн 25-ны дотор сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын хог хаягдлын асуудал хариуцсан хэлтэст хүргүүлнэ.
- 4.11. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:
- а) хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях;
 - б) нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях;
 - в) хог хаягдлыг ил задгай шатаах;
 - г) гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах;
 - д) хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях;
 - е) аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;
 - ж) нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх.
- 4.12. Барилга эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж байгууллага нь энэ стандарт шаардлагыг бүрэн биелүүлсэн байна.
- 4.13. Барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа энэ журмын дагуу барилгын хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгсөн эсэхийг харгалзан Барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын дүгнэлтэд тусгана.

5. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД¹

5.1. Барилгын хог хаягдал дараах эх үүсвэртэй байна. Үүнд:

- баригдаж байгаа барилгаас үүсэх хаягдал;
- ашиглагдаж байгаа барилгаас үүсэх хаягдал;
- барилга буулгалтаас үүсэх хаягдал;
- хотын зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээнээс үүсэх хог хаягдал;
- барилгын материалын үйлдвэрээс үүсэх хог хаягдал;
- барилгын материалын худалдаанаас үүсэх хаягдал.

5.2. Барилгын 1м² талбайд ногдох барилгын дахин хэрэглэгдэхгүй хог хаягдлын нормативыг БНБД 81-95-12 /2020/ “Барилгын төсөв зохиох дүрэм”-ийн дагуу тооцно.

Хүснэгт 1. 1м² талбайд ногдох барилгын хог хаягдлын норматив

№	Барилгын төрөл	1м ² талбайд ногдох хог хаягдлын норматив, тн
1	Барилга байгууламж шинээр барих	0.013
2	Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх	0.015
3	Барилга байгууламжийг засварлах, тоноглох	0.017
4	Барилга байгууламжийг буулгах	0.024

5.3. Баригдаж буй барилгаас суурийн шороо, угсралтын үйл ажиллагаанаас хог хаягдал үүснэ.



Зураг 2. Суурийн шороо (Жишээ зураг)



Зураг 3. Барилга угсралтын хог хаягдал (Жишээ зураг)

¹ Улаанбаатар хотын хэмжээнд үүссэн хог хаягдлын хэмжээ жилд дунджаар 1.4 сая тонн бөгөөд үүнээс барилгын хог хаягдал 28 хувь буюу 0.4 сая тонн хог хаягдал үүсдэг байна.



Зураг 4. Сав баглааны хаягдал
(Жишээ зураг)



Зураг 5. Өнгөлгөөний
материалын хаягдал
(Жишээ зураг)



Зураг 6. Хаалга, цонхны
хаягдал (Жишээ зураг)

5.4. Ашиглагдаж буй барилгаас үүсэх барилгын хог хаягдлын дийлэнх хувийг засварын үеийн хог хаягдал эзэлнэ. Үүнд:

- хучилтын хэсэг, хаалга, цонх зэрэг том хаягдал, ханын цаас, хавтанцар, хавтан зэрэг өнгөлгөөний материалын хаягдал, засварт хэрэглэсэн барилгын материалын хаягдал, сав баглааны хаягдал гэх мэт хамаарна;
- барилга буулгалтын үеийн хог хаягдал харьцангуй олон төрөл байх бөгөөд барилгын төрлөөс хамаарна;
- хотын зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн ажил, засварын ажлаас үүссэн хог хаягдалд асфальт бетон, суурийн шороо, гантэг, бетон, резин зэрэг хавтан, инженерийн шугам сүлжээний хуучин хоолой, дулаалгын материалын хаягдал зэрэг хамаарна;
- барилгын материалын үйлдвэрээс үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнд хэрэглэж буй түүхий эдийн хаягдал, технологийн процессын үе шат бүрд үүсэх хаягдал, бэлэн бүтээгдэхүүний хаягдал үүснэ;
- барилгын материалын худалдаанаас ихэвчлэн эвдэрч, гэмтсэн материал, баглаа боодлын хаягдал үүснэ.

5.5. Барилга буулгалтын үеийн хог хаягдал харьцангуй олон төрөл байх бөгөөд барилгын төрлөөс хамаарна.

5.6. Хотын зам, талбай, ногоон байгууламж, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн ажил, засварын ажлаас үүссэн хог хаягдалд асфальт бетон, суурийн шороо, гантэг, бетон, резин зэрэг хавтан, инженерийн шугам сүлжээний хуучин хоолой, дулаалгын материалын хаягдал үүснэ.

5.7. Барилгын материалын үйлдвэрээс үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнд хэрэглэж буй түүхий эдийн хаягдал, технологийн процессын үе шат бүрд үүсэх хаягдал, бэлэн бүтээгдэхүүний хаягдал зэргээс бүрдэнэ.

5.8. Барилгын материалын худалдаанаас ихэвчлэн эвдэрч, гэмтсэн материал, баглаа боодлын хаягдал үүснэ.

6. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ АНГИЛАХ, ХАДГАЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА²

6.1. Барилгын хог хаягдал үүсгэгч нь барилгын хог хаягдлаа эх үүсвэр дээр нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх шинж чанараар тодорхойлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны А/349 дүгээр тушаалын эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн “аюултай”, “хяналттай”, “энгийн” зэрэглэлд хамрагдсанаар нь ангилан ялгана.

Хүснэгт 2. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт /Барилгын хог хаягдал бүлэг/

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл
17	Барилга, барилгын материалын хог хаягдал (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно)	1701	Бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал	170101	Бетон
				170102	Тоосго
				170103	Өнгөлгөөний хавтан болон керамикийн хаягдал
				170104	Хортой бодис агуулсан бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн холимог хаягдал болон ангилж ялгасан хаягдал
				170105	17 01 04-д зааснаас бусад бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн холимог хаягдал
		1702	Мод, шил, хуванцар	170201	Мод
				170202	Шил
				170203	Хуванцар
				170204	Хортой бодисоор бохирдсон мод, шил, хуванцар

² Нийт хог хаягдлын 85 хувийг дахин боловсруулах, дахин ашиглах боломжтой байдаг бөгөөд үүнийг эх үүсвэр дээр нь ангилах нь нэн тэргүүний асуудал юм.

		1703	Битумын холимог, нүүрсний давирхай болон давирхайжсан бүтээгдэхүүнүүд	170301	Нүүрсний давирхай агуулсан битумын холимог
				170302	17 03 01-д зааснаас бусад битумын холимог
				170303	Нүүрсний давирхай болон бусад давирхайжсан бүтээгдэхүүн
		1704	Металл, тэдгээрийн хайлш	170401	Зэс, хүрэл, гууль
				170402	Хөнгөн цагаан
				170403	Хар тугалга
				170404	Цайр
				170405	Төмөр, ган
				170406	Цагаан тугалга
				170407	Холимог металл
				170408	Хортой бодисоор бохирдсон металл
				170409	Тос, давирхай болон бусад төрлийн хортой бодис агуулсан кабель
				170410	17 04 09-д зааснаас бусад кабель
		1705	Хөрс (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно), чулуу, хурдас	170501	Хортой бодис агуулсан хөрс, чулуу
				170502	17 05 01-д зааснаас бусад хөрс, чулуу
				170503	Хортой бодис агуулсан хурдас
				170504	17 05 03-д зааснаас бусад хурдас
				170505	Замын хортой бодис агуулсан хайрга, шороо
				170506	17 05 05-д зааснаас бусад замын хайрга, шороо
		1706	Дулаалгын материал, асбест агуулсан барилгын материал	170601	Асбест бүхий дулаалгын материал
170602	Хортой бодис болон түүнийг агуулсан бусад дулаалгын материал				
170603	17 06 01, 17 06 02-д зааснаас бусад дулаалгын материал				
170604	Асбест агуулсан барилгын материал				
1707	Гипс суурьт барилгын материал	170701	Хортой бодисоор бохирдсон гипс суурьт барилгын материал		
		170702	17 07 01-д зааснаас бусад гипс суурьт барилгын материал		
1708	Барилгын бусад хаягдал	170801	Мөнгөн ус агуулсан барилгын хаягдал		
		170802	Полихлорт бифенил (PCBs) агуулсан барилгын хаягдал (Полихлорт бифенил (PCBs) агуулсан чигжээс, Полихлорт бифенил (PCBs) агуулсан резинэн шал, Полихлорт бифенил (PCBs) агуулсан чигжээстэй шил, Полихлорт бифенил (PCBs) агуулсан конденсатор)		
		170803	Барилгын хортой бодис агуулсан бусад хаягдал (холимог хаягдал орно)		
		170804	17 08 01, 17 08 02, 17 08 03-д зааснаас бусад холимог хаягдал		

6.2. Дараах барилгын хог хаягдлыг дахин боловсруулах боломжтой. Үүнд:

- цаас /обой, төрөл бүрийн боодлын цаас, картон цаас, хаягдал цаас/;
- хуванцар /төрөл бүрийн гялгар уут, баглаа боодол, бүх төрлийн шингэн материалын сав, сантехникийн шугам хоолой, цахилгааны тоноглол, кабель, хаалга, цонхны хүрээ PVC/;
- хөнгөн цагаан, төмөр, металл, зэс, гууль, тэдгээрээр хийсэн бүх төрлийн материал бүтээгдэхүүн/;
- шил /бүх төрлийн шилэн сав, хийц, эдлэл, шилэн бүтээгдэхүүн/;
- мод, модон эдлэлийн хаягдал;
- төрөл бүрийн шуудай, даавуун материалын хаягдал;
- дуу дулаан тусгаарлах материалууд, хөөсөнцрийн хаягдал;
- резин, уур, ус, чийгээс хамгаалах бүх төрлийн хуйлмал материалууд;
- өвс, мод, чулуу;
- бүх төрлийн бетон, төмөр бетон эдлэл;
- тоосго, чулуу, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал;
- автозамын асфальт бетон, битумын холимог, замын хайрга, шороо;
- хаягдал арматур, бүх төрлийн төмөр эдлэл;
- бүх төрлийн цахилгаан, холбооны кабелийн утас;
- бүх төрлийн сав, баглаа, боодол;
- барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо.



Зураг 7. Цаас, обой
(Жишээ зураг)



Зураг 8. Хаалга, цонхны хүрээ
(Жишээ зураг)



Зураг 9. Хаягдал төмөр
(Жишээ зураг)



Зураг 10. Авто замын хуучин
асфальт бетон (Жишээ зураг)



Зураг 11. Хаягдал мод, модон
эдлэл (Жишээ зураг)



Зураг 12. Шил, шилэн эдлэл
(Жишээ зураг)



Зураг 13. Хаягдал арматур
(Жишээ зураг)




Зураг 14. Картон цаас
(Жишээ зураг)




Зураг 15. Зэс, гууль
(Жишээ зураг)

6.3. Дараах хог хаягдлыг дахин ашиглах боломжтой. Үүнд:

- суурийн блок;
- бүх төрлийн ялуу;
- хучилтын хавтан, татанга, төмөр бетон дам нуруу;
- тоосго, ханын блок, угсармал барилгын ханын хавтгайлж;
- модон эдлэл, эдлэхүүн;
- бүх төрлийн сав, баглаа, боодол;
- барилгын суурь ба талбайн тэгшилгээ, цэвэрлэгээнээс гарсан хөрс шороо.



Зураг 16. Суурийн блок
(Жишээ зураг)



Зураг 17. Бүх төрлийн ялуу
(Жишээ зураг)



Зураг 18. Төмөр бетон дам нуруу (Жишээ зураг)



Зураг 19. Модон эдлэл
(Жишээ зураг)



Зураг 20. Тоосго /ашиглаж болохыг ялгаж/ (Жишээ зураг)



Зураг 21. Хучилтын хавтан
(Жишээ зураг)

6.4. Дараах барилгын хог хаягдлыг устгана. Үүнд:

- барилгаас гарсан дахин ашиглах, дахин боловсруулах боломжгүй хаягдал, асбест болон хортой бодис агуулсан, хортой бодисоор бохирдсон, мөнгөн ус агуулсан хаягдлууд;

- бохирдсон буюу хортой бодис агуулсан хөрс, шороо, чулуу, нунтаг шороо, бетон, тоосго, өнгөлгөөний хавтан, керамикийн хаягдал, мод, шил, хуванцар.




Зураг 22. Хаягдал асбест хавтан
(Жишээ зураг)



Зураг 23. Бохирдсон бетон, тоосго,
керамикийн хаягдал (Жишээ зураг)

7. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

7.1. Барилгын хог хаягдал үүсгэгч нь барилга, байгууламж, явган хүний зам талбай, ногоон байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх, засварлах, тоноглох, буулгахад үүсэх хог хаягдал болон барилгын материалын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарсан хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, талбайг чөлөөлнө.



Зураг 24. Барилгын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж талбайг чөлөөлөх

7.2. Нийслэл, дүүргийн Засаг дарга нь Хог хаягдлын тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд нутаг дэвсгэртээ зөвшөөрөлгүй газар асгасан барилгын хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина.

7.3. Баг хорооны Засаг дарга барилгын хог хаягдлыг харьяалах нутаг дэвсгэрт нь зориулалтын газар хаяж байгаа эсэхэд хяналт тавина.

8. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


8.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын хог хаягдал тээвэрлэх тохиолдолд барилгын хог хаягдал үүссэн байршил бүхий баг, баг хорооны Засаг даргад мэдэгдэж бүртгүүлнэ.

8.2. Барилгын хог хаягдал тээвэрлэх зөвшөөрөлтэй этгээд /тээвэрлэгч/ хууль тогтоомжид нийцсэн тээвэрлэлтийн гэрээг барилгын хог хаягдлыг үүсгэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй байгуулж тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

8.3. Хог хаягдал үүсгэгч этгээдтэй гэрээ байгуулсан тээвэрлэгч хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.

8.4. Барилгын хог хаягдлыг хүлээн авах эрх бүхий байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- а) хог хаягдлыг хүлээн авах авто пүүтэй байна;
- б) диспетчерийн байртай байна;
- в) хог хаягдлын мэдээллийн санг үүсгэсэн байна;
- г) зориулалтын авто гаражтай байна;
- д) тусгай зориулалтын машин, техник, хэрэгсэлтэй байна.



Зураг 25. Барилгын хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагааны зураглал (Жишээ зураг)

8.5. Барилгын хог хаягдлыг тээвэрлэх автомашин нь “Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS4598:2011 стандартын шаардлагыг хангаж, техникийн хяналтын үзлэгт хамрагдан, гэрчилгээ авсан байна.

8.6. Барилгын хог хаягдлыг тээвэрлэгч нь хог хаягдлыг зориулалтын зөвшөөрөгдсөн цэгээс бусад газар хаяж болохгүй.

8.7. Барилгын хог хаягдлыг тээвэрлэгч нь замын хөдөлгөөнд аюул учруулахгүйгээр соёлтой оролцож, зам дээр хог хаягдлыг асгахгүй байх арга хэмжээг авч ажиллана.

8.8. Барилгын хог хаягдлыг тээвэрлэгч нь хог хаягдал тээвэрлэх тэвштэй буюу өөрөө буулгагч тээврийн хэрэгсэл нь хог хаягдлыг гээгдэхээс хамгаалах зориулалтын хэрэгсэлтэй, өндөрлөгөө, хашлага, бүтээлэгтэй байна.



Зориулалтын өндөрлөгөө, хашлага, бүтээлэгтэй байна. Хог тээвэрлэх автомашин

Зураг 26. Барилгын хог тээвэрлэх автомашин (Жишээ зураг)

- 8.9. Барилгын болон газар шорооны ажлын үед гарсан шимт хөрсийг хот тохижуулах байгууллагад тээвэрлэж хүргэнэ.
- 8.10. Барилгын сууриас гарсан шороог газрын нөхөн сэргээлтэд дүүргэгчээр ашиглахын тулд тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн хадгалах талбайд тээвэрлэж хүргэнэ.

9. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА³

- 9.1. Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах замаар эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэнэ.
- 9.2 Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрийг тухайн аймаг, Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр үйлдвэрлэлийн бүсэд олгогдсон газарт барьж байгуулна.
- 9.3 Барилгын хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгэлтэй, эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж гүйцэтгэх ба дахин боловсруулж шинээр гарган авсан бүтээгдэхүүн, эдлэхүүн, дахин боловсруулалтаас гарсан хог хаягдлын тоо, тайлан мэдээг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.



Зураг 27. Дахин боловсруулах үйлдвэрлэлийн зураглал (Жишээ зураг)

³ Нийслэл хотод 2019 оны байдлаар дахивар нөөцийн 206 цэг байх бөгөөд дахин боловсруулах чиглэлээр хуванцар, хаягдал моторын тос, хаягдал шил, хаягдал дугуй, хаягдал картон цаас, хаягдал хөнгөн-цагаан, хаягдал аккумулятор, хар тугалга дахин боловсруулах үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байна.

9.4 Дахин боловсруулж гаргаж авсан барилгын материал, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг лабораторийн шинжилгээнд хамруулж, чанар байдалд дүн шинжилгээ хийлгүүлэх бөгөөд сорьцын дүнг гаргуулан тухайн материал бүтээгдэхүүний холбогдох бөгөөд стандартад нийцүүлсэн байна.



Зураг 28. Сандал
(Жишээ зураг)



Зураг 29. Резин хавтан
(Жишээ зураг)



Зураг 30. Хуванцар хоолой
(Жишээ зураг)



Зураг 31. Шил
(Жишээ зураг)



Зураг 32. Хуванцар эдлэл
(Жишээ зураг)



Зураг 33. Ариун цэврийн цаас
(Жишээ зураг)

9.5. Хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүн болон дахин боловсруулагдах хог хаягдал үүсгэх бүтээгдэхүүн нь таних тэмдэгтэй байна.

9.6. Дахин боловсруулалтаас үүссэн хог хаягдлыг зөвшөөрөлтэй хог хаягдлын төвлөрсөн цэгт хүргэнэ.

10. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫГ УСТГАХ, БУЛШЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

10.1. Төвлөрсөн цэгт барилгын хог хаягдал устгах үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

10.2. Барилгаас үүссэн дахин боловсруулах боломжгүй хог хаягдлыг /аюултай хог хаягдал хамаарахгүй/ энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгт булшилж устгана.

10.3. Барилгын хог хаягдлыг устгах, булшлах зардлыг Хог хаягдлын тухай хуулийн 9.1.4-т заасан энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифаар тооцно. (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 48 дугаар тушаал, 6.4).

10.4. Барилга байгууламжийн буулгалтаас үүсэх хог хаягдлын норматив хэмжээг “Барилгын төсөв зохиох дүрэм” БНБД 81-95-12*/2020/-ийн дагуу тооцно.



Зураг 34. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн байршил (Жишээ зураг)

11. БАРИЛГЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

- 11.1. Барилгын аюултай хог хаягдлыг “Хог хаягдлын тухай” хуулийн “Аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах” бүлэгт заасны дагуу устгана.
- 11.2. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд савлаж, агааржуулалтын системтэй, тухайн хаягдлыг хадгалах нөхцөлийг хангасан орчинд хадгална.
- 11.3. Аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх байгууламж, аюултай хог хаягдлыг устгах зориулалт бүхий байгууламжид эцсийн устгал хийгдэнэ.

Хүснэгт 3. Барилгын аюултай хог хаягдлын жагсаалт

Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл
17 03	Битумын холимог, нүүрсний давирхай болон давирхайжсан бүтээгдэхүүнүүд	17 03 01	Нүүрсний давирхай агуулсан битумын холимог
		17 03 03	Нүүрсний давирхай болон бусад давирхайжсан бүтээгдэхүүн
		17 04 08	Хортой бодисоор бохирдсон металл
		17 04 09	Тос, давирхай болон бусад төрлийн хортой бодис агуулсан кабель
17 05	Хөрс (бохирдсон газраас ухаж гаргасан хөрс орно), чулуу, хурдас	1705 01	Хортой бодис агуулсан хөрс, чулуу
		17 05 03	Хортой бодис агуулсан хурдас
		17 05 05	Замын хортой бодис агуулсан хайрга, шороо
17 06	Дулаалгын материал, асбест агуулсан барилгын материал	17 06 01	Асбест бүхий дулаалгын материал
		17 06 02	Хортой бодис болон түүнийг агуулсан бусад дулаалгын материал
		17 06 04	Асбест агуулсан барилгын материал
17 07	Гипс суурьт барилгын материал	17 07 01	Хортой бодисоор бохирдсон гипс суурьт барилгын материал
17 08	Барилгын бусад хаягдал	17 08 01	Мөнгөн ус агуулсан барилгын хаягдал
		17 08 02	Полихлорт бифенил (PCBs) агуулсан барилгын хаягдал (Полихлорт бифенил (PCBs) агуулсан чигжээс, Полихлорт бифенил (PCBs) агуулсан резинэн шал, Полихлорт бифенил (PCBs) агуулсан чигжээстэй шил, Полихлорт бифенил (PCBs) агуулсан конденсатор)
		17 08 03	Барилгын хортой бодис агуулсан бусад хаягдал (холимог хаягдал орно)




Зураг 35. Асбест агуулсан барилгын материал (Жишээ зураг)

11.4. Барилгын аюултай хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь үүсгэсэн хог хаягдлаа тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгахтай холбогдон гарах зардалд шаардагдах аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс төлнө.

12. БАРИЛГЫН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ⁴

12.1. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь эх үүсвэр дээр нь бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглахад орших бөгөөд харин сөрөг нөлөөтэй, ашиглах боломжгүй хаягдлыг устгана.



Зураг 36. Хог хаягдлын менежментийн зарчим (Жишээ зураг)

12.2. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам” –ын 2.3-ын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-тэй ажиллана.

12.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд барилгын хог хаягдлын урсгал хэмжээ, бүтэц, материалын үнэ, хог хаягдлыг тээвэрлэх үнэ, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах материалын хэмжээ, ландфилл-д устгах хог хаягдлын хэмжээ, цуглуулах чингэлэг, ачих машин механизм, хандив ба материалын солилцоо, жин, үнэ зэргийг тус бүрд нь тусгана.

12.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд барилгын хог хаягдлын урсгал хэмжээ, бүтэц, материалын үнэ, хог хаягдлыг тээвэрлэх үнэ, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах материалын хэмжээ, ландфилл-д устгах хог хаягдлын хэмжээ, цуглуулах чингэлэг, ачих машин механизм, хандив ба материалын солилцоо, жин, үнэ зэргийг тус бүрд нь тусгана.

12.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд барилгын талбай дээр хог хаягдлыг ангилж хадгалах, хог хаягдал дахин боловсруулах байгууламжид цуглуулах, тээвэрлэх давтамж, ашгийн бус цуглуулах агентлаг, хот тохижилтын газар, материал солилцоо ба ландфилл-д устгах зэрэг календарьчилсан төлөвлөгөө байна.

⁴ Барилгын хог хаягдлын менежментийн зорилго нь удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгалийн нөөц баялгийг хэмнэх, эдийн засгийн эргэлтэд оруулах явдал юм.

- 12.6. Хог хаягдлыг ангилсан, дахин боловсруулсан хэмжээг батлах баримт бичиг, дахин боловсруулах компанид борлуулсан баримт зэргийг хавсаргана.
- 12.7. Барилгын компани материалын төрлийг тодорхойлж барилгын процессын явцад тусад нь ангилж ялгасан ба холимог хог хаягдлын чингэлгийг байрлуулна.
- 12.8. Дахин боловсруулах ба үйрмэг хог хаягдал хийх чингэлгийг барилгын талбайн гадна ба дотор төлөвлөнө.
- 12.9. Барилга байгууламжийг буулгах үйл ажиллагааг Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-т заасан тусгай зөвшөөрөл авсан аж ахуй нэгж, байгууллага 26 дугаар зүйлийн 26.1.3 -т заасан барилгын ажлын зөвшөөрөл авсны үндсэн дээр гүйцэтгэнэ.
- 12.10. Барилга байгууламжийн буулгалтаас үүсэх хог хаягдлын норматив хэмжээг “Барилгын төсөв зохиох дүрэм” БНБД 81-95-12*/2020/-ийн дагуу тооцно.
- 12.11. Айл, өрхийн нийтийн болон амины орон сууцны засвараас үүссэн хог хаягдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дагуу зохицуулах ба “Барилга доторх хог хаягдлын менежмент-Ашиглалтын дүрэм” MNS BS 5906:2018 стандартыг мөрдлөг болгоно.

Хүснэгт 4.Барилгын хог хаягдлын менежментийн сургалтын жишиг төлөвлөгөө

№	Хичээлийн агуулга
1	Барилгын хог хаягдлын эх үүсвэрүүд ба эх үүсвэр дээр нь хаягдлыг бууруулах боломж
2	Барилгын хог хаягдлыг дахин ашиглах боломж нөхцөл, гадаад орны туршлага
3	Барилгын аюултай хог хаягдал ба тэдгээрийг зайлуулах арга технологи
4	Барилгын хог хаягдлын хууль эрх зүйн орчин, тэдгээрийн хэрэгжилт
5	Барилгын хог хаягдлын тухай норм, дүрэм, стандарт
6	Барилгын хог хаягдлын менежментийн өнөөгийн түвшин
7	Барилга буулгалтын технологи ба ангилан ялгалт, тэдгээрийг дахин ашиглах боломж
8	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Барилгын тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль
- Хот байгуулалтын тухай хууль
- Стандартчилал, техникийн зориулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр (2014 оны 9 дүгээр 18-ны МУ-ын ЗГ-ын 298 дугаар тогтоол)
- МУ-ын ЗГ-ын Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох талаар авах арга хэмжээний тухай 2001 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 256 дугаар тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (МУ-ын ЗГ-ын 2016 оны 121 дүгээр тогтоол)
- Ногоон хөгжлийн үзэл баримтлал, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (МУ-ын ЗГ-ын 2016 оны 35 дугаар тогтоол)
- Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах журам (Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 48 дугаар тушаал)
- Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/428 дугаар тушаал)
- БНБД 81-95-12 /2020/ барилгын төсөв зохиох дүрэм
- MNS BS 5906:2018 Барилгын доторх хог хаягдлын менежмент - Ашиглалтын дүрэм
- MNS 6830:2020 Дахин боловсруулалтаас гарсан бетонон дайрга. Техникийн шаардлага
- “Барилгын хог хаягдлын менежментийн суурь судалгаа”, КЧР ТББ, 2017 он
- “Монгол Улсад барилгын хог хаягдлыг дахин боловсруулах боломжийн судалгаа”, КЧР ТББ, 2017 он
- George Tchobanoglous, INTEGRATED SOLID WASTEMANAGEMENT, 1993
- Mulders L. (2013), High quality recycling of construction and demolition waste in the Netherlands, <https://dspace.library.uu.nl/handle/1874/279530> (MSc thesis), accessed on 3/5/2018

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.

ТЭМДЭГЛЭЛ

Blank lined paper with horizontal dotted lines for writing.



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар